

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ХҮРЭХ ТҮВШИНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хяналтад авч, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, зорилтот түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар 3 шалгуур үзүүлэлт тусгагдсан ба тэдгээрийн гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг доорх хүснэгтэд харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (хувь)
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	70.0
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	100.0
3.	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	70.0

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд

хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-д туссан суурь түвшинг, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-д туссан 2022 оны хүрэх түвшинтэй харьцуулан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1 болон 6.2.2 дах заалтын аргачлалыг хослуулан тооцсон болно.

2. Суурь, зорилтот болон хүрсэн түвшин тодорхой боловч "Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь" шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцоход учир дутагдалтай (сөрөг утга гарах) тул 6.2.2-т заасан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцсон болно.
3. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-д "Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь" шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь харгалзах он буюу 2015 оны импорт, хэрэглээний хэмжээ, нийт шатахуунд эзлэх хувь гэж тодорхой туссан байна. Харин "Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь" шалгуур үзүүлэлтийн суурь түвшин хэдэн он болох нь тодорхойгүй, "Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь" шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-д туссан 2022 оны хүрэх түвшингээс их үзүүлэлттэй байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд учир дутагдалтай байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох аргачлал, хугацаа, мэдээллийн эх сурвалжийг тодорхой болгох,
2. "Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь" шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг хэрхэн тодорхойлсныг тогтоох, цаашид хэрхэн тайлагнах, хүрэх түвшинг ямар аргачлалаар тооцох зэрэг асуудлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж шийдвэрлэх шаардлагатай байна.

Хянасан:
ХШУДАГ-ын дарга



Б.Мөнхдөл

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:
ХШУДАГ-ын мэргэжилтэн *Н. Энхсайхан* Ж.Энхсайхан

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Тайлант хугацаанд хүрсэн түвшин	Мэдээлэл цуглуулах арга зүй, эх үүсвэр	Зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан нөхцөлийн тайлбар	Үнэлгэ /хувь/
			он	түвшин	он	түвшин				
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	-	24.3	2022	26.8	22.8 Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 22.8%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70.6%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 64.2%, нийт экспортын 93.9%, улсын төсвийн 23.8%-ийг тус тус бүрдүүлж байна. Уул уурхайн салбарын орлого зэсийн баяжмал, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг голлох ашигт малтмалаас төвлөрч байна. Дээрх дөрвөн голлох нэр төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 95%-ийг бүрдүүлж байна.	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт; Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт; Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	БНХАУ-ын Замын-Үүд, Гашуунсухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт буурсан.	70.0
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	-	10.9	2022	9.8	11.7 2022 оны III улирлын байдлаар боловсруулах үйлдвэрийн ДНБ (оны үнээр)-д эзлэх хувь 6.1% байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 12.8%-иар өссөн үзүүлэлттэй байна. 2022 оны эхний 11 сарын байдлаар 474.7 мян.тн баяжуулсан нүүрс, 524.8	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт; Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт;	Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 20.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 (17.2%) их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна. Үүнд уул уурхай, олборлох 2.4 (20%) их наяд төгрөг, боловсруулах аж үйлдвэр 435.2 (11.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.	100.0

							мян.тн нүүрсэн шахмал түлш, 8,936.2 тн катодын зэс, 21,567.8 тн металл бэлдэц, 22,975.9 тн металл цувимал, 3,374.1 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс катодын зэс 254.2 тн буюу 2.9 хувиар өссөн байна. Харин баяжуулсан нүүрс 3,301.3 мян.тн буюу 87.4 хувь, нүүрсэн шахмал түлш 109.1 мян.тн буюу 17.2 хувь, металл бэлдэц 11,506.7 тн буюу 34.8 хувь, металл цувимал 10,065.2 тн буюу 30.5 хувь, ган төмөр хийц 370.3 тн буюу 9.9 хувиар тус тус буурсан байна.	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл 2022 I-XI		
3.	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	хувь	-	8	2022	25	22.3 Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2022.12.12-ны өдрийн байдлаар нийт 1.7 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэнээс, 1.5 сая тонн шатахуун байна. Үүнээс Евро-5 /K5/ стандартын шаардлагад нийцсэн 346 мян.тонн шатахуун байгаа нь нийт импортолсон шатахууны 22,3 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 36 хувиар	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт; Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт; УУХУСайдын 2018 оны A/08 дугаар тушаалаар батлагдсан Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй	Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6-д “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон (2022.04.22). Ийнхүү агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлага хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн. Монгол, Оросын иж бүрэн стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт “Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 2022 оны 24 дүгээр хуралдааны протоколд болон ОХУ-ын “Роснефть” НХН болон Монголын шатахуун импортлогч	70

						<p>өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>2022 оны 12 дугаар сард БНХАУ-аас 20 мянган тонн Евро-5 шатахуун авахаар захиалга хийгдсэн.</p>	<p>холбоотой нарийвчилсан журам</p> <p>Гаалийн ерөнхий газрын газрын тосны бүтээгдэхүүний импортын мэдээлэл</p>	<p>компаниудын хооронд байгуулсан 2023 он хүртэл шатахуун нийлүүлэх урт хугацааны гэрээний дагуу шатахууныг тогтвортой нийлүүлэх, тэр дундаа K5 /Евро-5/ ангиллын шатахууны нийлүүлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх саналыг тусгасан.</p> <p>Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулгыг 2022.02.24-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн бөгөөд шатахууны гадаад үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан дизелийн түлшний Гаалийн албан татварыг "0" хувиар, НӨАТ-ыг "0" хувиар тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.</p> <p>Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.07.28-ны өдрийн 287 дугаар тогтоолын дагуу 2023 оны 1 дүгээр сарыг дуустал импортлох дизель түлш дээр энгийн болон Евро-5 ялгаваргүй онцгой албан татварыг "0" төгрөг болгон тус тус бууруулж шинэчлэн тогтоосон.</p> <p>Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан 2025-2026 онд ашиглалтад орсноор газрын тосны бүтээгдэхүүний 60 хувийг дотоодоос хангах нөхцөл бүрдэнэ. Боловсруулах үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна.</p>
--	--	--	--	--	--	--	---	---

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт тус бүрээр хяналтад авч, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 зорилго, 3 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилтийн явц 62.5 хувиар үнэлэгдэв.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн
үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл

№	Арга хэмжээ	Үнэлгээ (хувь)
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.		
Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:		
4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.		
1.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх	30.0
2.	“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	50.0
Зорилт 4.2.1. үнэлгээний хувь		40.0 эрчимжүүлэх шаардлагатай
4.2.11. Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.		

3.	Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах	50
4.	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх	70
5.	"Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	30
Зорилт 4.2.11. үнэлгээний хувь		50.0 эрчимжүүлэх шаардлагатай
Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:		
4.6.1. Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна.		
6.	Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх	70.0
Зорилт 4.6.1. үнэлгээний хувь		70.0 тодорхой үр дүнд хүрсэн
Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.		
Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно:		
6.2.4. хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ.		
7.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	90.0
Зорилт 6.2. үнэлгээний хувь		90.0 тодорхой үр дүнд хүрсэн
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын үнэлгээний дүн		62.5

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг, 4.1.12-т "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг хэлнэ гэж тус тус заасан. Үүний дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.
2. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан суурь болон зорилтот түвшинтэй харьцуулах замаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн


хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцсон болно.

3. "Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ" арга хэмжээний хүрсэн түвшин тодорхойгүй байна. Учир нь Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалтын дагуу ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж тайлагнадаг.
4. Зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээнүүдийг үр дүнтэй болгох зорилгоор холбогдох газрууд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд үнэлгээ өгч, санал, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Холбогдох нэгжүүд зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг тайлагнахдаа тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг товч бөгөөд тодорхой бичиж, зорилтот түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгааныг бичиж хэвших,
2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажил эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан тодорхой шалтгааны улмаас хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай зорилт, арга хэмжээг цаг хугацаа, нөхцөл байдалд бодит үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр дээрх төлөвлөгөөнд тусгуулах,
3. Холбогдох нэгжүүд биелэлт гаргахдаа Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5-д заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тайлагнаж хэвших.

Хянасан:
ХШУДАГ-ын дарга



Б.Мөнхдөл

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:
ХШУДАГ-ын мэргэжилтэн *Н. Энхсайхан* Ж.Энхсайхан

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
/2022 он/

№	Зорилго, зорилт, арга хэмжээ	Төсөв	Санхүүжилтийн эх үүсвэр	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт (2022 он)		Хэрэгжилт/үр дүн	Тайлбар	Үнэлгэ (хувь)
					Суурь түвшин	Зорилтот түвшин			
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахуун дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.									
Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:									
4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.									
1.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх	63,195.0	Улсын төсөв	1,500.0	Гүйцэтгэл 10 хувьтай байна.	Гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 2022 оны байдлаар 7%-тай хэвээр байна.	Цар тахалтай холбоотой төсөв хэмнэх Засгийн газрын чиглэлийн дагуу төсвийн санхүүжилт танагдсан. Мөн БНХАУ-ын Гашуунсухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурсантай холбоотой "Эрдэнэс Монгол ХХК-д санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул төсөл арга хэмжээнүүд тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.	30
2.	"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	134,485,1 сая төгрөг	Гадаад, дотоод хөрөнгө оруулалт (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өөрийн хөрөнгө)	980.5 сая төгрөг	Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулсан /5 хувь/.	Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээ барих ажлыг эхлүүлнэ /100 хувь/.	Үйлдвэр технологийн паркийн (ҮТП) авто зам, төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл, төсвийг 100% гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100% гүйцэтгэж, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна. Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц барьж байгуулах ажлын хүрээнд: - Автозам барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 3 дахь	Захиалагч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Автозам барих зураг төсөл боловсруулах тендерийг 2021.08.05-ны өдрөөс эхлэн 2 удаа зарлаж Зураг төслийг 2022.03.21-ний өдөр хүлээн авсан, төмөр зам барих зураг төсөл боловсруулах тендерийг 2021.08.18-ны өдрөөс эхлэн нийт 4 удаа зарлаж зураг төслийг 2022.04.09-ний өдөр хүлээн авсан, Ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл	50

							удаагийн тендер хүчингүй болсон, 4 дэх тендер зарлахаар ажиллаж байна. - Төмөр зам барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 2 дахь удаагийн тендерийг 2022.11.07-нд зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээж үнэлгээ хийгдэж байна. - Ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах ажлын тендер хүчингүй болсон. Дахин тендер зарлахаар ажиллаж байна. - Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэхээр болж, ажлын төсөвт өртгийг батлуулах ажил хийгдэж байна. "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн Засаг дарга нар 2022.10.25-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу 2022.11.14-ний өдөр №000000019 дугаартай газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна.	боловсруулах тендерийг 2021.08.06-ны өдрөөс эхлэн 2 удаа зарлаж, зураг төслийг 2022.05.01-ны өдөр хүлээн авсан, Автозам барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 3 дахь удаагийн тендер хүчингүй болсон, 4 дэх тендер зарлахаар ажиллаж байна. - Төмөр зам барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах 2 дахь удаагийн тендерийг 2022.11.07-нд зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээж үнэлгээ хийгдэж байна. - Ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах ажлын тендер хүчингүй болсон. Дахин тендер зарлахаар ажиллаж байна.	
4.2.1. үнэлгээний хувь							40		
4.2.11. Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.									
3.	Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах	397,0 сая ам.дол лар	Төр-хувийн хэвшлийн түншлэл	14.7 сая ам.доллар	Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг тусгай хэрэгцээнд авсан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан	Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилт 40	Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан "Улсын тусгай хэрэгцээ"-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12 дугаар сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт,	УУХҮЯ-ны ТНБД-ын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан. Цар тахлын нөхцөл байдлын улмаас сонгон шалгаруулалт удааширч 2022 оны 3 дугаар сард Норинко компанийг шалгаруулсан. Хоолой барих ажлын санхүүжилтийг бүтээгдэхүүн урьдчилан	50

					байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	хувьд хүрсэн байна.	дагалдах баримт бичгийн бүрдэлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхүүлээд барилга угсралтын ажил-35%, түр замын ажил-15%, геодезийн цэг тэмдэгт суулгах ажил-100%, байр зүйн зураглалын судалгааны ажил-100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил-60%, геотехникийн судалгааны ажил-80%, дээжлэлт шинжилгээ-80%. Тосон-Уул 19, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17,5 л ба 16,7 л дээж авч тосны дээж авсан. Тус дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторид илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад улсын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь инженерчлэлийн загвар (FEED) боловсруулах ажлыг 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил-25% байна. БОАЖЯ-наас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННУ хийх ажил-90% байна.	борлуулах замаар санхүүжүүлэх тухай Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 94 дүгээр тогтоол гарсан. Үүний дагуу талууд 2022.04.18-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний хүрээнд Норинко компани инженерийн зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна.	
4.	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх	3,521,780.1	Гадаадын зээл, тусламж	288,456.9	Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн лицензтэй байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензтэй байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 60 хувьд хүргэсэн байна.	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна. Эдгээрт түүхий ус хадгалах сав-98,69%, оффис, сургалтын төв-80,68%, хоолны газар-89,82%, лаборатори-89,17%, эмнэлгийн барилга-83,84%, агуулах-58,47%, нэвтрэх хаалга-1-82,80%, нэвтрэх хаалга-2-56,32%, гал унтраах ангийн барилга-68,29%, засварын цех-51,0%, үерийн ус цуглуулах талбай-82,5%, ус зайлуулах хоолой-53,0%, ус дамжуулах хоолой-95%, 17 км авто зам-60,63%, ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, худгийн барилга-79,74%, цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ний өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер	Цар тахлын нөхцөл байдал, тендерт ирүүлсэн үнийн саналаас шалтгаалан /ЕРС-2/, /ЕРС-3/ багц ажлын шалгаруулалт удааширсан. Түргэвчилсэн тендер явуулж 2022.10.28-ны өдөр ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээг байгуулсан. /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, ерөнхий гүйцэтгэгчийг шалгаруулах ажил хийгдэж эхэлсэн	70

							<p>хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructure Limited" (Мега инженеринг инфрастратчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Megha Engineering & Infrastructure Limited" компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс техноложу компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, гидрокрекинг, дизелийн гидроцэвэрлэгээ, дизелийн гидроцэвэрлэгээ, шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан.</p>		
5.	<p>"Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх</p>	123,446.0	<p>Гадаад дотоод хөрөнгө оруулалт (30% Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өөрийн хөрөнгө, 70% гадаад, дотоод хөрөнгө оруулалт)</p>	7,084.6	<p>Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан /1 хувь/.</p>	<p>Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженерийн зураг төсөл боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гүйцэтгэлийг 7.5 хувьд хүргэсэн байна.</p>	<p>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан. Тус ТЭЗҮ-ийг үндэслэн Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын "Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж" боловсруулсан. Үүний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны газарт 2022.09.22-ны өдөр хүргүүлсэн ба Үнэлгээний хороо байгуулагдаж тендер зарлахаар ажиллаж байна. Валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тус ажлын төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн 2023 оны хөрөнгө</p>	<p>БНХАУ дахь Ковид-19 цар тахлын аливаа хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх, үйлдвэрийг барих, туршилтыг явуулах, эцсийн тайлан ба дүгнэлтийг гаргах ажил удааширч үүнтэй холбогдуулан зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг тодотгох болон үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлууд удаашраад байна.</p>	30

						<p>оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн. Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 98%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 96%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн.</p> <p>Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн хяналт шалгалтуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба үйлдвэрлэгчийн агуулахаас тээвэрлэхэд бэлэн болоод байна. Гэвч БНХАУ-д үүсээд буй Ковид-19 цар тахлын хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх боломжгүй байгаа тул туршилтын ажлын гүйцэтгэлийн хугацааг 2023.11.10-ны өдөр дуусгах төлөвлөгөөг гүйцэтгэгчээс ирүүлсэн.</p> <p>Тус төлөвлөгөөтэй холбогдуулан Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах туршилтын ажлыг эрчимжүүлэх талаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.10.07-ны өдрийн "Үйлдвэрлэлийн туршилтын ажлын тухай" албан бичгийг БНХАУ-ын "China ENFI engineering" корпорацийн Ерөнхийлөгч Liu Cheng болон "ENFI судалгаа хөгжлийн институт"-ын захирал Yao liang нарт хүргүүлээд байна.</p> <p>Мөн туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон төсөл хэрэгжүүлэх талбайн бүтээн байгуулалтын ажлыг оновчтой зохион байгуулж, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023 оны I улиралд багтаан бүрэн дуусгахад "China ENFI</p>	
--	--	--	--	--	--	---	--

							<p>Engineering" корпорацид дэмжлэг үзүүлэх хүсэлтийг БНХАУ-ын холбогдох төрийн байгууллагад зохих журмын дагуу уламжлах хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2022.11.10-ны өдрийн 01/2938 дугаар албан бичгээр БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Цай Вэнь Руйд хүргүүлсэн. "China ENFI engeneering" корпорациас 2022.11.15-ны өдөр ирүүлсэн албан бичигт туршилтын үйлдвэрийг 2023.05.30-нд барьж дуусган, туршилтын ажлын үр дүнг 2023.06.30-ны өдрийн дотор гаргасан байх тухай албан ёсоор мэдэгдсэн.</p> <p>"China ENFI engeneering" корпорацийн зүгээс зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төслийн хөгжүүлэлт, нийт хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний гарцын чиглэлээр "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа 2022.11.23-ны өдрийн албан бичгээр илэрхийлээд байна.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.12.19-ний өдрийн өргөтгөсөн шуурхай хурлаас өгсөн чиг үүргийн дагуу Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар "China ENFI Engineering" корпорацид 2022.12.22-ны өдөр дахин албан бичиг хүргүүлсэн бөгөөд "China ENFI Engineering" корпорациас 2022.12.23-ны өдөр ирүүлсэн албан бичигт төслийн хэрэгжилтийг хангах чиглэлээр талууд 2022.12.29-ний өдрийн 14:00 цагт цахим хурал хийх хүсэлтийг ирүүлсэн. "China ENFI Engineering" корпораци болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд Т.Бадрал нарт туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг эрчимжүүлэх асуудлаар 2022.12.23-ны өдөр албан бичиг хүргүүлсэн.</p>		
4.2.11. үнэлгээний хувь								50	
Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:									
4.6.1. Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж хөгжүүлсэн байна.									
6.	Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд	-	-	-	Ажлын хэсэг байгуулж, төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.	Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төрийн нийтийн өмч болох газрын	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар		70

	<p>өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх</p>					<p>хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, байгалийн шавхагдах баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгалийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үедээ тэгш, шударга хуваарилах боломжтой болно.</p>	<p>байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичиг, материалуудыг УУХҮСайдын 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлээд байна.</p>		
--	--	--	--	--	--	--	---	--	--

4.6.1. үнэлгээний хувь

70

Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж ууг амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах ашиглалтын нөөц бий болгоно:

6.2.4. Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ.

7.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх		Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл	40,000.0	1973.9 га талбайд техникийн, 634.8 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Уул уурхайн компаниудын 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 507.7 га-д, биологийн нөхөн сэргээлтийг 306.2 га-д, дүйцүүлэх хамгаалах ажлыг 1388.8 га-д нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. "Оюу толгой" ХХК Ялбаг орчмын 334.57 га, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 га талбайд нөхөн сэргээлтийн тендер зарлаж сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. Нийслэлийн ЗДТГ-аас Налайх дүүргийн 3 дугаар хороонд нүүрсний олборлолтын улмаас эвдрэлд орсон 40 га газрыг нөхөн сэргээх ажлын тендер зарласан. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дахь заалтын дагуу 2022 оны уулын ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2 дугаар сард ирүүлдэг.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайг нөхөн сэргээлт хийх зардал шийдэгдээгүйн улмаас төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.	90
6.2.4. үнэлгээний хувь								90	
Үнэлгээний дүн								62.5	

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ